



МОНГОЛ УЛС  
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2017 оны 01 сарын 30 өдөр

Дугаар 5/18

Хэрлэн сум

Хөдөлмөрийн гэрээг цуцалж,  
ажлаас чөлөөлөх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр 29.2, Соёлын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2, Хөдөлмөрийн тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.1.1, 40 дүгээр зүйлийн 40.1.2, 43 дугаар зүйлийн 43.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Аймгийн Музейн захирал Ц.Эрдэнэбулган нь эрүүл мэндийн шалтгааны улмаас ажлаас чөлөөлөгдөх өөрийн хүсэлтээ гаргасан тул 2017 оны 1 дүгээр сарын 30-ны өдрөөс эхлэн хөдөлмөрийн гэрээг цуцлан албан тушаалаас нь чөлөөлсүгэй.

Хоёр. Ц.Эрдэнэбулгантай холбогдох тооцоог зохих хууль, журмын дагуу хийж дуусгахыг нягтлан бодогч /Г.Тунгалаг/-т даалгасугай..

Гурав. Аймгийн Музейн захирлын ажил хүлээлцэх комиссыг доорх бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Комиссын дарга:	Г.Лхагвахатан	-Нийгмийн бодлогын хэлтсийн дарга
Гишүүд:	Ц.Мөнгөнзул	-Нийгмийн бодлогын хэлтсийн мэргэжилтэн
	Э.Сайнзаяа	-Музейн тайлбарлагч, бичиг хэрэг

Дөрөв. Музейн захирлын ажлыг 2017 оны 01 дүгээр сарын 31-ний өдөр хүлээлцүүлэхийг Нийгмийн бодлогын хэлтсийн дарга /Г.Лхагвахатан/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Н.ГАНБЯМБА